



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ОЛОН УЛСЫН УЛААНБААТАР ИХ СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: ЭДИЙН ЗАСАГ

Индекс: D031101

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Нямаа

Гишүүд: С.Эрдэнэтуул

П.Эрдэнэбат

2022.04.22

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам гэх мэт
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ОУУБИС	Олон Улсын Улаанбаатар Их Сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ЭЗ	Эдийн засаг
ЭЗС	Эдийн засгийн сургууль
ЭЗТ	Эдийн засгийн тэнхим

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Олон улсын Улаанбаатар их сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Эдийн засаг	
Индекс	D031101	
Шинжээчид	<p>Ахлагч: Н.Нямаа Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессорын багийн ахлагч, доктор</p> <p>Гишүүд: С.Эрдэнэтуул Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, доктор</p> <p>П.Эрдэнэбат Отгонтэнгэр их сургуулийн Эдийн засаг-Бизнесийн удирдлагын сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор</p>	
Зохицуулагч	Б.Сүнжидмаа Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.03.30	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №А/70
	2022.03.30	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022.04.08	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.04.12,13	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.04.21	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022.04.25	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2022.04.26	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Олон Улсын Улаанбаатар Их Сургууль нь БНСУ-ын 100% хөрөнгө оруулалттай анхны их сургууль бөгөөд байгууллагын магадлан итгэмжлэлд 3 удаа орж магадлан итгэмжлэгдсэн. БНСУ-ын их сургуулиудтай хамтарсан бакалаврын болон магистрын хос дипломтой төгсөх боломжтой. БНСУ, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг улсаас оюутнууд ирж суралцдаг. Хамтарсан хөтөлбөрөөр суралцах оюутныг солонгос хэлний ТОPIK шалгалтад бэлтгэх хэлний бэлтгэлийн сургалттай.

Тус сургууль нь бүх мэргэжлийн ангиуддаа Солонгос хэл, Англи хэлний хичээлийг гүнзгийрүүлэн судалдаг. Оюутан бүр Солонгосын шилдэг их сургуулийн хөтөлбөрөөр “Хувь хүний хөгжил” сургалтад заавал хамрагддаг. БНСУ-ын 105 \хамгийн сүүлийн мэдээ\ их сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг ба тогтмол зуны сургалтыг зохион байгуулдаг. Хамгийн их тэтгэлэгт олгодог-захирлын, спорт, урлагийн, сурлагын, халамжийн, цагийн ажлын гэх мэт 30 гаруй тэтгэлгүүдийг олгодог.

“Эдийн засаг” хөтөлбөрөөр анх 2003 оноос эхлэн сургалт явуулж эхэлсэн бөгөөд 2007 онд анхны төгсөлтөө хийсэн. 2003 оноос хойш уг хөтөлбөрөөр тасралтгүй жил бүр төгсөлт хийж, нийт 15 удаагийн төгсөлтөөр 730 гаруй мэргэжилтнийг бэлтгэж төгсгөсөн.

ОУУБИС-ийн ерөнхий захирлын 2010 оны 09 дугаар сарын 01-ний А/60 тоот тушаалаар эдийн засгийн салбарын харьяанд “Эдийн засаг”-ийн тэнхим болон салбарлаж тусдаа тэнхимийн бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимд Ерөнхий суурь хичээл-14, Мэргэжлийн суурь хичээл-24, Мэргэжлийн хичээл - 24 заадаг. Нийт 64 хичээлийг 33 багш зааж байна. Үүнд, доктор, дэд профессор- 4, доктор, ахлах багш-6. Сүүлийн 5 жилд ОУ-ын болон дотоодын байгууллагын санхүүжилттэй 10 төсөлд ажиллаж, 30 өгүүлэл, илтгэл, 8 зохиогчийн эрхийг эзэмшдэг. 2010-2021 онд докторын зэрэг 4 багш хамгаалсан.

Одоогоор “Эдийн засаг” хөтөлбөрөөр нийт 69 оюутан суралцаж байна. Хөтөлбөрийн зорилго нь “Олон улсын түвшний боловсрол эзэмшүүлж, Монголын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үнэнч шударга, хүний эрхийг дээдэлдэг, итгэл, найдвар хайрыг эрхэмлэдэг, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх”-д оршино.

“Эдийн засаг” мэргэжлийн хөтөлбөр нь Монгол Улсын БШУС-ын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу сүүлийн 5 жилд 3 удаа шинэчлэн сайжруулагдсан. Сүүлийн 5 жилд төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл, 80% ажил эрхэлж, 14% нь дахин суралцаж мэргэжил, мэдлэгээ дээшлүүлж байна.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ
- Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа
- Хөтөлбөрт оролцогч, талуудаас жил бүр авсан сэтгэл ханамжийн болон хэрэгцээ, шаардлагын судалгаануудын тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын 2, дотоодын 2 их сургуулийн ижил мэргэжлийн хөтөлбөртэй хичээлийн болон кредитийн харьцуулалтыг хийсэн. МУИС-ийн “Эдийн засаг” хөтөлбөртэй харьцуулсан судалгаанаас харахад, Мэргэжлийн суурь хичээлийн 62.0 хувь, мэргэшүүлэх хичээлийн 64.0 хувь нь ижил хичээлүүд бөгөөд агуулгын хувьд ч дүйж байна. СЭЗИС-ийн “Эдийн засаг” хөтөлбөртэй харьцуулсан харьцуулалтаар, мэргэжлийн суурь хичээлийн 71.0 хувь, мэргэшүүлэх хичээлийн 63.0 хувь нь ижил хичээлүүд байв.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн онцлог, давуу талыг тодорхойлж бусад ижил мэргэжлээр төгсөгчдөөс ялгарах ялгааг хөтөлбөрт харуулж чадсан.
- ОУУБИС нь БНСУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай сургууль тул БНСУ-ын нэр хүнд бүхий их сургуулиудын ижил хөтөлбөрүүдийн дэвшилтэт давуу талыг Монгол орны нөхцөлд тохируулан нутагшуулж чадсан.
- “Алсын хараа 2050”, МУ-ын дээд боловсролын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн судалгааг гүйцэтгэж хөтөлбөрийн хэтийн төлвийг тодорхойлохдоо тусгасан.

Анхаарах асуудал:

- PEST, STEEP шинжилгээнүүд бүрэн гүйцэд биш байгааг анхаарч гүнзгийрүүлэн судлах
- Хөтөлбөрөөр төгсөгчийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийн хэтийн төлвийн судалгааг нарийвчлан гаргах

Зөвлөмж:

- Оролцогч, сонирхогч талуудын эрэлт, хэрэгцээнд үндэслэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг бүрэн гүйцэд гаргах
- БНСУ-ын их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж буй туршлага дээрээ тулгуурлан хөтөлбөрийн олон улсад болон БНСУ-д зөвшөөрөгдөх байдлыг баталгаажуулах боломжийг судлах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийг хөгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- ОУУБИС-ийн дүрэм
- ОУУБИС-ийн Бакалаврын сургалтын журмын эмхэтгэл
- ОУУБИС-ийн болон ЭЗ-ийн сургууль, ЭЗ-ийн тэнхимийн танилцуулга
- ОУУБИС-ийн захирлын, ЭЗС-ийн захирлын тушаалууд \хөтөлбөрийн хороо, хөтөлбөртэй холбоотой\

Онцлог зүйл/Туршлага:

- Оролцогч болон сонирхогч талуудаас жил бүр сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнд нь хөтөлбөрт сайжруулалтыг хийдэг.
- Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилттой нийцсэн.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагын судалгаанд тулгуурласан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгын томъёоллыг найруулга зүйн хувьд сайжруулах
- Төгсөгчийн загварыг хэт ерөнхий байдлаар томъёолсон байгааг сайжруулж үр дүнгийн матрицтай уялдуулах
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээллэх мэдээллийн сувгийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан ба сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцэж байгаа хэдий ч олон нийтэд түгээх мэдээллийн хэлбэр, сувгийг нэмэгдүүлэх
- Төгсөгчийн загварыг нарийвчлан боловсруулж хэвлэгдсэн байгаа “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичигт оруулах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, дэд хорооны хурлын тэмдэглэл \хөтөлбөрийн талаар хэлэлцсэн хурлуудын тэмдэглэл\
- Батлагдсан сургалтын төлөвлөгөөнүүд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график
- “Эдийн засаг” хичээлийн хөтөлбөр

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөр, график батлагдсан хууль, журмын хүрээнд байна. Сургалтын төлөвлөгөөг БСШЯ-аас баталсан тогтоол шийдвэрийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн гадаад, дотоодын их сургуулиудын хөтөлбөрийн жишигт нийцүүлэхээр байнга өөрчлөн сайжруулсан.
- Хөтөлбөрт суралцагч, ажил олгогч, төгсөгчид, багш нараас сэтгэл ханамжийн судалгааг авахаас гадна суралцагчдын эцэг, эхээс сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч хэвшсэн. Хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудаас авсан судалгааны үр дүнд тулгуурлан өөрчлөлт, сайжруулалт хийдэг бөгөөд үүнийг тайланд тусгаж харуулдаг.
- Сургалтын арга зүйн өөрчлөлтийг 2014 онд “Уламжлалт сургалт”, 2016 онд “Идэвхтэй сургалт”, 2019 онд “Үр дүнд суурилсан сургалт” хийсэн. Ингэснээр хөтөлбөрийн үр дүнд, хичээлээр олгох мэдлэг, чадвар, хандлагад үндэслэн үнэлгээг олон талт хэлбэрээр үнэлдэг болсон.
- Төгсөгчид нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад ажиллах боломжтой бөгөөд 2+2 хөтөлбөрөөр дотоод, гадаадын их сургуулийн хос дипломтой төгсөх боломжтой. Эдийн засгийн сургуулийн 2+2 хөтөлбөрт хамрагдсан оюутны эзлэх хувь – 28%, хөтөлбөрийн оюутнуудын эзлэх хувь – 9.2% байна.
- “Оюутан солилцоо”-ны хөтөлбөрт Эдийн засгийн сургуулийн хамрагдсан хувь – 41%, Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Эдийн засгийн тэнхимийн оюутнуудын эзлэх хувь – 13.8% байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сайжруулалт, өөрчлөлтийн үр дүнг зэрэгцүүлсэн судалгааг нарийвчилж дүн шинжилгээ хийх
- Сургалтын төлөвлөгөөнд оюутны чөлөөтэй сонгох хичээлүүдийн хувь харьцангуй бага хувийн жин эзэлж байгааг анхаарах

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд оюутны чөлөөт сонголтын хичээлийг нэмэгдүүлэх
- Төгсөгчдийн мэргэжлийн салбарт хөрвөх чадварыг судлахдаа гадаад, дотоодын ижил хөтөлбөрүүдээс туршлага судлах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ

- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан Санал болгох төлөвлөгөө

Онцлог зүйл/Туршлага:

- Ерөнхий суурь хичээлүүд 36 кр буюу 32.7 хувийг, Мэргэжлийн суурь хичээл 24 кр буюу 21.8 хувийг, Мэргэжлийн хичээл \дадлагын хамт\ 50 кр буюу 45.0 хувийг тус тус эзэлдэг. Оюутан суралцах хугацаандаа 12 кредитийн хичээлийг сонгон судлах бөгөөд үүний 6 кредит нь Мэргэжлийн суурь, 6 кредит нь Мэргэжлийн хичээл байна. Ерөнхий, Мэргэжлийн суурь, Мэргэжлийн хичээлүүдийн нийт кредитэд эзлэх хувийн жин батлагдсан стандарт хэмжээнд байна.
- Суралцагч нь солонгос хэл, англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй төгсдөг. Суралцах хугацаандаа гадаад хэлний хичээлийг 12 кредитээр заавал болон сонгон судлах хэлбэрээр судалдаг. Төгсөгчдийн 61.2 хувь нь Солонгос хэлний ТОРИК 3 ба 4 шатны, 28.5 хувь нь ТОРИК 5 ба 6 шатны мэдлэгтэй төгсдөг.
- Төгсөгчдийн 31.2 хувь нь Солонгосын хөрөнгө оруулалттай компанид ажилладаг. Төгсөгчдийн 27.0 хувь нь БНСУ-ын их сургуулиудад үргэлжлүүлэн суралцдаг.
- Сургалтын төлөвлөгөөнд “Суралцах арга зүй”, “Судалгааны арга зүй” хичээлүүдийг тусгасан нь оюутныг судлаач, шинжээч болж төгсгөхөд хувь нэмэр оруулдаг. “Суралцах арга зүй”, “Солонгос хэл”-ний хичээлүүдийг Солонгос багш нар заадаг. Хичээл заадаг Солонгос багш нар нь Монгол хэлний ахисан түвшний мэдлэгтэй, их, дээд сургуульд багшилсан туршлагатай багш нар байдаг.
- Удирдлагын мэдээллийн системийг сайн хөгжүүлж оюутны сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйл ажиллагааны оролцоо, бусад холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн агуулсан.
- Онол, практикийн мэдлэгийг хичээлийн явцад эзэмшихээс гадна Танилцах дадлага, Мэргэшүүлэх дадлагын явцад эзэмшдэг. Танилцах болон мэргэшүүлэх дадлагын удирдамжийг тасралтгүй сайжруулж ирсэн ба хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн.

Анхаарах асуудал:

- Суралцагч багшийг сонгох нөхцлийг бүрдүүлээгүй.
- Хичээлүүдийн стандарт хөтөлбөрт хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог уялдуулж гаргах, зарим хичээлийн сэдэв, агуулга давхардаж байгааг анхаарах

Зөвлөмж:

- Суралцагчийн сонгох хичээлийн тоог нэмэгдүүлэх, багшийг сонгох нөхцөлийг бүрдүүлэх
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байгаа “Ерөнхий хими”, “Ерөнхий биологи” хичээлүүдийг хасаж тухайн хөтөлбөрөөр суралцагчдад мэргэжлийн чиглэлийн дагуу мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хичээлүүдийг оруулах
- “Бизнесийн шинжилгээ” хичээлийг бакалаврын түвшинд судлуулах
- Мэргэшүүлэх сонгон хичээлд мэргэжлийн чиглэлийн хичээлүүдийг нэмж оюутанд хичээл сонголтыг хийх боломжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, Зардал өгөөжийн шинжилгээ, Ногоон эдийн засаг, Нөөцийн эдийн засаг, Тоглоомын онол, Институцийн эдийн засаг, Нийгмийн эдийн засаг, Эрсдэлийн шинжилгээ гэх мэт.
- Мэргэжлийн суурь болон Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах. Хичээлүүдийн стандарт хөтөлбөрүүдийг сайжруулахдаа Эдийн засгийн мэргэжлийн нэр хүнд бүхий сургуулиудаас мэргэшсэн багш нарын зөвлөгөөг авах.

Шаардлага:

- Сургалтын төлөвлөгөөнд тухайн мэргэжлээр суралцагчдын мэдлэг, ур чадварт хамааралгүй “Ерөнхий хими”, “Ерөнхий биологи” хичээлүүдийг сонголтоор оруулсан.
- Мэргэжлийн хичээлүүдийн сонголтыг нэмэгдүүлэх

- Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөр дэх сэдвийн давхардлыг арилгах
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийгээгүй.

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Бакалаврын сургалтын дүрэм, журмын эмхэтгэл
- Оюутны гарын авлага
- Багшийн гарын авлага
- Сургалтын аргазүйн зөвлөлийн ажлын төлөвлөгөө
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын дүрэм, журамд өөрчлөлт, сайжруулалтыг байнга хийдэг. Хөтөлбөрийн агуулга, арга зүйтэй холбоотой сайжруулалтыг тасралтгүй хийж ОУУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 2 жил тутамд хэлэлцүүлэн батлуулсан.
- Сургалтад е-сургалтын олон хэлбэр, аргуудыг ашигладаг. Бүх хичээлийн е-сургалтын материалыг иж бүрэн боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтад мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашигладаг болох нь харагдсан хэдий ч сургалтад ашиглаж буй эдийн засгийн судалгаа, шинжилгээний программ хангамжууд нь E-Views, SPSS-ээр хязгаарлагдаж байгааг анхаарах

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйг өөрчилж сайжруулснаар хүрсэн үр дүнг тодорхойлсон судалгааг хийх
- Эдийн засгийн судалгаа, шинжилгээнд ашиглагддаг орчин үеийн Stata, R, Vensim, Smart PLS зэрэг программ хангамжуудын лицензийг худалдан авч сургалтдаа ашиглах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгааны тайлан
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ \анги, ангиар\
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанарын судалгаа/

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн үнэлгээг дүрэм, журмын хүрээнд шударга байх зарчмыг баримтлан дүгнэдэг. Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа, суралцагчийн үнэлгээний дүнг хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэж хэвшсэн.
- Явцын болон улирлын шалгалтыг хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагад чиглүүлж хичээл бүрийн онцлогт тохирсон олон арга хэлбэрийг ашигладаг.
- Суралцагчдад практик мэдлэг олгоход чиглэсэн Танилцах дадлага, Үйлдвэрлэлийн дадлагын байнгын, гэрээт бааз суурьтай.

Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгааг нарийвчлан гүйцэтгээгүй.
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/ тайланд тусгагдаагүй.

Зөвлөмж:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгааг нарийвчлан гүйцэтгэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, интернэт үйлчилгээ үзүүлэх төв, бие даан болон багаар ажиллах танхим, зай талбайн ашиглалт, спортын заал, уншлагын танхим, оюутан үйлчлэх төв, орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын судалгаа, сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт явуулах анги, танхим, багшийн ажиллах орчин зэрэг нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагыг хангасан.
- Сургуулийн харьяанд Компьютер, Гадаад хэл, Гэр бүлийн зөвлөгөө, Боловсролын онол арга зүйн төв, Гэр бүл судлалын лабораторитой. Эдгээр төв, лабораториудыг орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр тоноглож оюутны сурч боловсрох таатай нөхцөлийг үлгэр жишээ авахуйцаар тохижуулж чадсан.
- Тэргэнцэртэй оюутны хэрэгцээнд зориулж оюутны болон төв байрны орох гарах хэсэгт зориулалтын шат шийдсэн, харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулан номын санд тусгай төхөөрөмж байрлуулж ашигладаг, оюутны чөлөөт цагаа өнгөрүүлэхэд дэмжлэг болгон ашиглах тав тухтай орчныг бүрдүүлсэн танхим байгуулсан.

- МУ-ын бусад их сургуулиуд жишээ авахуйц тав тухтай хоолны газар, кофе шоп-уудыг ажиллуулдаг.
- Сургуулийн байр, танхимд халдваргүйжүүлэлт хийж ажилладаг, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан.
- Цахим хичээлд зориулж студи байгуулж багш нарын цахим хичээлээ бэлдэх орчинг бүрдүүлсэн.
- Багш, ажилчдын нийгмийн асуудалд анхаарч багш нарын хүүхдүүдийг түр хугацаанд харах өдөр өнжүүлэх хэлбэрийн өрөөг тохижуулсан.

Анхаарах асуудал:

- “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагчдад ашиглагддаг “Компьютерын төв”-ийн зарим эгнээний компьютерүүдийг хүчин чадал сайтай компьютерээр шинэчлэх
- Интернет үйлчилгээний хурд, хүртээмжид анхаарах

Зөвлөмж:

- Мэдээллийн технологийн хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, хүртээмжийг сайжруулах
- Интернетийн үйлчилгээний хурдыг сайжруулах, тасалдалгүй ажиллагааг хангах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын алба, номын сангийн программ, санхүүгийн хэлтсийн программ, эрдэм шинжилгээний албаны дотоод веб
- Интернет төв, эрдэм шинжилгээний уншлагын танхим
- Компьютерын лаборатори
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах дүрэм журам
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Онцлог зүйл/Туршлага:

- Е-контент түвшинд иж боловсруулсан сургалтын материалтай бөгөөд цар тахлын үед бүрэн ашиглаж сургалтыг явуулсан.
- Интернет төв, эрдэм шинжилгээний уншлагын танхим, Компьютерын лабораториудын тохижилт нь БНСУ-ын их сургуулиудынхтай дүйж байна.
- Хөтөлбөрийн хичээлүүдийг компьютерын лабораторид SPSS v.20, E-views программ хангамжийг ашиглан зааж байна.

Анхаарах асуудал:

- “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн программ хангамжийг нэмэгдүүлэх
- Албан ёсны эрхтэй программ хангамжийг ашиглахад анхаарах
- Оюутнуудын Ms-Excel программ дээр ажиллах чадварыг сайжруулахад анхаарах

Зөвлөмж:

- Зайн сургалтыг явуулах боломжийг судлах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа, ном ашиглалтын судалгаа, сайжруулах арга хэмжээ
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн цахим катологи, ашиглаж буй компьютерүүд, программ хангамж, тохижилт сайтай. Номын сангаас ном авч уншихаас гадна хичээлээ хийх орчинг оюутнуудад зориулан бүрдүүлсэн.
- Жил бүр төсөв баталж шинэ номыг худалдан авдаг тогтолцоотой. Хэдийгээр цар тахлын үед шинэ ном худалдан авалт буурсан ч энэ жил шинээр олон ном худалдан авч байна.
- Хөтөлбөртэй холбоотой 2323 төрлийн 15108 ном сурах бичиг ашиглаж байгаагаас цахим сурах бичиг 59, мэргэжлийн сурах бичиг 750 байна.
- Солонгос хэл дээр ашиглах номын фондтой.

Анхаарах асуудал:

- Цахим сурах бичгийн ашиглалт болон гадаад номын ашиглалтыг сайжруулах

Зөвлөмж:

- Олон улсын эрдэм шинжилгээ, цахим сангуудыг нэмэгдүүлэх
- Багш, судлаачдад зориулж гадаадын өндөр эрэмбийн сэтгүүлийг цахимаар унших эрхийг худалдан авах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн дэд хорооны хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрийн дэд хорооны шийдвэрүүд

- Хөтөлбөрийн баримт бичиг
- Хөтөлбөрт ирсэн санал гомдлын жагсаалт, шийдвэрлэлтийн тайлан
- Эдийн засгийн тэнхимийн тайлан, төлөвлөгөө

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хорооны бүтэц, үйл ажиллагааг зураглаж журмыг шинэчлэн баталж, хууль, эрх зүйн орчинд үйл ажиллагаагаа явуулж байна.
- Хөтөлбөрийн урт болон богино хугацааны төлөвлөлтийг 2013 – 2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд үндэслэн хийсэн.
- Эдийн засгийн тэнхимийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, ахиц дэвшил 2016 – 2021 онд жил бүрийн гүйцэтгэл 100 хувьтай байна.
- Оюутны санал хүсэлтийг бүртгэлжүүлсэн бөгөөд сүүлийн гурван жилд оюутнаас гаргасан өргөдөл, гомдол буурсан.
- Суралцагчийн эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулан, тайланг ном болгон хэвлүүлж хэвшсэн. Үүнийг бусад их, дээд сургуулиуд нийтлэг хийдэггүй тул онцлог, давуу талтай байна.
- Төгсөгчийн холбоог байгуулан, төрийн бус байгууллагын тамга, тэмдэг, гэрчилгээгээ авсан, гишүүд нь үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчийн хөтөлбөрийн хөгжүүлэлтэд оролцох оролцоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнг эргэн мэдээлэх сувгийг бий болгох

Зөвлөмж:

- Оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн динамик шинжилгээг хийж хэвших, үр дүнг оролцогч талуудад эргэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх
- Шинэчилсэн хөтөлбөрт ажил олгогчдоос санал авах, дүгнэлт гаргуулах, хэлэлцүүлэгт татан оролцуулах, судалгаа авах зэргээр тэдний хөтөлбөрийн сайжруулалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хос хөтөлбөрийн гэрээ
- Оюутан солилцооны хөтөлбөр, гэрээ
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн хувьд БНСУ, ОХУ, АНУ, БНХАУ зэрэг орнуудын 95 их, дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. 2014 оноос хойш 34 их, дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ шинээр байгуулсан.
- 2016 оноос эхлэн БНСУ-ын NanYang их сургуулийн багш, оюутны багтай хамтран тэнхимийн оюутнуудад зуны сургалтыг зохион байгуулж байна.

- Монгол Солонгосын хамтарсан “Эдийн засаг, бизнесийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг гурван удаа зохион байгуулсан.
- БНСУ-ын Нам Сөүлийн их сургуультай хамтран 2+2 хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар 40 гаруй суралцагч солонгос хэлний бэлтгэлд хамрагдаж байна.
- Сүүлийн 3 жилд бизнесийн болон төрийн байгууллагад 18 сургалт, бизнесийн байгууллагын 5 захиалгат судалгааг гүйцэтгэсэн байна.
- Төгсөгчдийн холбооноос тэнхимтэй хамтран “Төгсөгчдөд зориулсан сургалт”-ыг 3 удаа амжилттай зохион байгуулжээ.
- Сэжү Хагдан сургалтын төв сургуулийн дэргэд ажиллаж, нэмэлтээр суралцагчдад солонгос хэлнийхээ түвшнийг ахиулах боломжийг олгож байна. Сургалтын төлбөр нь сургуулийн оюутнуудад 100.0 мянган төгрөг байна.

Анхаарах асуудал:

- Судалгаа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтын ажиллагаатай байгууллагуудыг өргөжүүлэх, судалгааны ажилд дээд түвшний оюутнуудыг татан оролцуулах
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоод, бизнесийн байгууллагуудтай судалгаа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах боломжит чиглэлүүдээ тодорхойлон, багш нарыг идэвхжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийт орлогын 90 гаруй хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байгаа бөгөөд орлого сүүлийн гурван жилд тогтвортой байна.
- Нийт зардлын 80.0 хувийг цалингийн зардал, 5.0 хувийг тоног төхөөрөмжийн зардал, 8.0 хувийг ашиглалтын зардал, 3.0 хувийг сургалт, хөгжлийн зардал, 0.4 хувийг ном, сурах бичгийн зардал, 0.1 хувийг эрдэм шинжилгээний зардал эзэлж байна. Сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ, ном, сурах бичиг, сургалт хөгжлийн зардлууд бүгд өссөн дүнтэй байна.
- 2021 онд ОУУБИС-ийн “Инновац, эрдэм шинжилгээний ажлын талаар баримтлах бодлого”, “Судалгааны санхүүжилтийн журам”, “Багш ажилчдын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх журам” зэргийг батлан гаргасан.

Анхаарах асуудал:

- Сургуулийн бодлогод эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх олон зорилт туссан боловч санхүүжилтийн үр дүнгийн уялдаа холбоо тааруу.
- Ном, сурах бичиг, багшийн хөгжил, судалгаа, эрдэм шинжилгээний зардлын нийт зардалд эзлэх хувь бага байгааг анхаарах

Зөвлөмж:

- Судалгааны санхүүжилттэй холбоотой гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайланг дэлгэрэнгүй байдлаар боловсруулах
- Сургалтын төлбөрөөс гадна нэмэлт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургууль, тэнхимийн санхүүгийн бие даасан байдлыг бүрдүүлэх боломжийг судлах

Шаардлага:

- Ном сурах бичиг, багшийн хөгжил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах зардлын хувийг нэмэгдүүлэх, сургуулийн стратеги төлөвлөгөөг санхүүжилттэй уялдуулах
- Хөтөлбөрийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, элсэлтийн тодорхой бодлого гарган ажиллах

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, холбогдох материал
- Идэвхжүүлэлтийн талаар хийсэн ажлын тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжил сурталчлах өдөрлөг, салбарын менежерүүдтэй хийх уулзалт, бүрэн дунд сургуулийн төгсөх ангийн хүүхдүүдэд мэргэжил сурталчлах өдөрлөг, сургалтыг зохион байгуулж хэвшсэн.
- Элсэгчдэд зориулсан блог ажиллуулж эхэлсэн.
- Сургуулийн веб хуудас байнгын ажиллагаатай.
- Элсэлтийн зохион байгуулалт, орон нутгийн элсэлтийн үйл ажиллагаанд оюутнуудыг татан оролцуулж, урамшуулалттай ажиллуулдаг.
- Элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт, хөгжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр суралцагчийн тоо харьцангуй цөөн тул хөтөлбөрийн онцлогийг сайтар таниулах, хөтөлбөрийн давуу талуудыг сурталчлах үе шаттай алхмуудыг тэнхимийн зүгээс санаачлан зохион байгуулах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн дотоод мэдээллийн систем
- www.iuu.edu.mn хуудас

- Оюутны гарын авлага

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн дотоод мэдээллийн системийг өөрийн онцлогтоо нийцүүлэн хөгжүүлсэн.
- Сургуулийн веб хуудас байнгын ажиллагаатай, тогтмол мэдээллүүд тавигддаг.
- Төгсөгчийн холбоо өөрийн Facebook хуудас ажиллуулдаг бөгөөд гишүүд нь энэ сошиал хаягаар дамжуулан мэдээллийг цаг алдалгүй авдаг.

Анхаарах асуудал:

- Олон нийгэд мэдээлэл түгээх сувгийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийн дүрэм
- ОУУБИС-ийн бакалаврын сургалтын журам
- Оюутан элсүүлэх журам
- Элсэлтийн комисс томилсон тушаал
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын судалгаа
- Элсэгчдэд зориулсан тараах материал

Онцлог зүйл/Туршлага:

- “Эдийн засаг” хөтөлбөрт элсэгчдийн дундаж оноо 520.
- Тухайн жилд ажиллах элсэлтийн комисс байгуулж элсэлтийн ажлыг зохион байгуулдаг.
- Элсэлтэд ажиллах багш, оюутнуудаас санал авч элсэлтэд ажиллуулдаг. Элсэлтэд ажилласан багш, оюутнуудад цагийн хөлс, урамшуулал олгодог.
- Элсэлттэй холбоотой мэдээллийг фэйсбүүк, ТВ зар ашиглан түгээдэг, элсэлтэд зориулсан өдөрлөг зохион байгуулдаг.

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан мэдээллийн агуулгыг сайжруулах, элсэлтийн маркетингийн бодлогыг илүү тодорхой болгох, элсэгчдэд мэдээлэл түгээх сувгуудыг сайжруулах
- Элсэгчдэд зориулсан мэргэжлийн чиглэл рүү хандсан арга хэмжээ зохион байгуулах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын албаны үйл ажиллагаа
- Оюутанд үйлчлэх албаны үйл ажиллагаа
- Сэтгэл ханамжийн судалгаа
- Зохион байгуулсан арга хэмжээний тайлан мэдээ
- Интернэт мэдээллийн төв
- Судалгааны төв
- Сэжүн хагдан сургалтын төв
- Хэлний төв
- Хувь хүний хөгжлийн үйл ажиллагаа
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- Сайн дурын нийгмийн үйлчилгээний төв
- Гэр бүлийн зөвлөгөө, боловсролын онол арга зүйн төв
- Эмч

Онцлог зүйл/Туршлага:

- Алба нэгжүүдийн үйлчилгээ, харилцааны талаарх судалгаа авч дүгнэж, цаашид хийх ажлыг төлөвлөж ажилладаг.
- Хувь хүний хөгжлийн сургалт тогтмолжсон, сургалтад хамрагдагсдын талаар судалгаа хийгддэг.
- ЭШХуралд оюутнуудыг удирдан оролцуулдаг бөгөөд Эврика ЭШХуралд байр эзэлсэн сайн туршлагатай, “Оюунлаг оюутан” клуб ажилладаг.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажиллагаа Оюутанд үйлчлэх албаар дамжин хэрэгждэг, оюутанд ажил эрхлэлтийн мэдээллийг хүргэн ажилладаг.
- Сургууль дээрх оюутанд зориулсан үйлчилгээний төвүүдэд оюутнуудыг цагаар ажиллуулдаг. Тухайлбал, кофе шоп, номын сан, Багш нарын хүүхдийг түр харах үйлчилгээ гэх мэт. Сургууль дээр ажиллах цагийн ажлын байрны зарыг нээлттэй зарладаг.
- Оюутанд Сэтгэл зүйн зөвлөгөөг мэргэжлийн багш нараар ганцаарчилсан ярилцлага хийх зориулалт бүхий өрөөнд тогтмол зохион байгуулж байна.
- Оюутанд Хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх зориулалтын төвтэй.
- Зөвлөх багш оюутанд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, тэнхимд үйл ажиллагаагаа тайлагнаж, үнэлүүлдэг.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйлчилгээтэй холбоотой тайланг тогтмол тайлагнаж, харьцуулалт хийж, дүн шинжилгээ тогтмол хийдэг байх

Зөвлөмж:

- “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”, “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв”, “Хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх төв” зэрэг төвүүд, оюутны сурах таатай нөхцөлийг үлгэр жишээчээр бүрдүүлсэн байдлыг сурталчилгаанд ашиглах боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээний хурал, олимпиадад оролцсон байдлын судалгаа
- Дугуйлангийн төлөвлөгөө
- Урлагийн их наадмын төлөвлөгөө
- Спортын арга хэмжээний төлөвлөгөө
- Мэргэжил сурталчлах өдөрлөгийн төлөвлөгөө
- Нийгмийн үйлчилгээний төв

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС нь суралцагчдад зориулсан маш олон тооны тэтгэлэг, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагчдын 1\3 нь ямар нэгэн тэтгэлэгт хамрагдсан байна. Тухайлбал: Нийгмийн үйлчилгээний тэтгэлэг, Удирдах зөвлөлийн даргын тэтгэлэг, Ерөнхий захирлын нэрэмжит тэтгэлэг, Урилгаар суралцаж байгаа оюутны тэтгэлэг, Голч дүнгийн тэтгэлэг, Спорт, оюутны зөвлөл, олимпиад, байгууллага хувь хүмүүсийн тэтгэлэг гэх мэт.
- Дотоодын болон гаднын тэтгэлгийн мэдээллийг оюутнуудад хүртээмжтэйгээр мэдээлж тэтгэлэгт хамрагдахад нь зөвлөн тусалдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг олон нийтийн ажилд оролцох оролцоог жигд болгох

Зөвлөмж:

- “Эдийн засаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн зүгээс мэргэжлийн чиглэлээр явуулж буй дугуйлангийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөөтэй байх
- “Оюутны хөдөлмөр эрхлэх төв” нь зөвхөн цагийн ажлаар бус, мэргэжлийн хэрэгцээнд тохирсон ажлыг байрыг санал болгоход анхаарах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа
- Бакалаврын сургалтын журам

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах журмаар шийдвэрлэдэг.
- Шилжилт хөдөлгөөний судалгааг нэгтгэн гаргадаг бөгөөд шилжилт, хөдөлгөөн харьцангуй бага, нэгэнт элссэн суралцагч тогтвортойгоор үргэлжлүүлэн суралцдаг.
- Шилжих болсон шалтгааныг зөвлөх багш болон тэнхимээр дамжуулан зөвлөн хэлэлцсэний дүнд шийдвэрлэдэг. Сүүлийн 5 жилийн хугацаанд нийтдээ 4 оюутан

сургуулиас гарсан бөгөөд сургуулиас гарсан шалтгаан нь эрүүл мэндийн болон гэр бүлийн нөхцөл, байдлаас хамаарсан байв.

Анхаарах асуудал:

- Оюутны шилжилт хөдөлгөөний статистик мэдээг он, оноор нь харьцуулан гаргаж, дүн шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагаандаа ашигладаг байх

Зөвлөмж:

- Сургалтын төлбөр төлөх уян хатан гэрээг оюутанд санал болгох

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын №4 тоот тушаалаар баталсан “Сургалтын журам”
- ОУУБИС-ийн ерөнхий захирлын №235 тоот тушаалаар баталсан Оюутныг төгсгөх журам
- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөгчдийн судалгаа
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн голч дүнгээс хамааруулан дипломын ажил бичих эсэхийг шийдвэрлэдэг. Сурлагын голч нь 3.5-аас дээш буюу харьцангуй чадварлаг оюутнууд диплом бичдэг тул дипломын ажлын чанар сайн байхад нөлөөлж байна.
- Төгсөлтийн шалгалттай холбоотой хяналтын дэвтэр боловсруулсан ба уг дэвтэр нь төгсөх ангийн оюутнуудад удирдамж болдог.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг аль болох дипломын ажил бичих тал дээр дэмжин ажиллах. Өөрөөр хэлбэл, хүссэн бүх оюутан дипломын ажил бичдэг болох тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах
- Дипломын ажилд тавих шаардлага, стандарт гаргаж мөрдүүлэх

Зөвлөмж:

- Төгсөгчдийн товч анкетын загвар боловсруулж мэдээллийн санг бүрдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн үндсэн 5 багш байгаа бөгөөд багш нарын 80 хувь нь доктор (Ph.D) зэрэгтэй.
- Багшийг сонгон шалгаруулах дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүд тодорхой. “Профессор багшийг ажиллуулах журам” – ийг 2021 онд шинэчлэн баталж, албан тушаалын зэрэглэл бүрд тавигдах шаардлагыг нарийвчилсан.
- Багшийн цагийн ачаалал, цагийн гүйцэтгэлийг тооцох журам нь төрийн өмчийн их сургуулиудынхтай адил төвшинд байна. Тухайлбал, “Багш” зэрэглэлийн жилийн ногдол нь 17 кредит гэх мэт.
- Сургуулийн стратегийн баримт бичигт багшийг хөгжүүлэх, судалгаа эрдэм шинжилгээний чадавхыг дээшлүүлэх асуудлуудыг тусгасан.
- Нэг багшид ногдох оюутны тоо дунджаар 20 бөгөөд багш нарын цагийн ачаалал хэвийн.
- “Багш, ажилчдын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх журам”-д өндөр эрэмбийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх, инновацын төслийг санхүүжүүлэх асуудлыг тусгасан.

Анхаарах асуудал:

- Нэг багшид ногдох мэргэжлийн хичээлийн тоог их биш байлгахад анхаарах

Зөвлөмж:

- Хэдийгээр багшийн тоог нэмэгдүүлэх нь оюутны тоотой хамааралтай ч цаашид Эдийн засгийн мэргэжлийн хичээл заадаг багшийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа
- Багш нарын эрдэм шинжилгээний болон сургалтын ажлын төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдмийн зэрэгтэй багш нарын тоо сүүлийн 3 жил дараалан өссөн байна.
- Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр эрх зүйн 3 баримт бичгийг боловсруулан гаргасан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.
- Багшийн хөгжлийн албыг байгуулан, хариуцсан орон тооны мэргэжилтнийг ажиллуулдаг.
- Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр багш бүрд сар бүр 100,000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлдэг. Багш нар жилийн эцэст сарын цалинтай тэнцэхүйц бонус цалин авдаг.

- 2017 оноос хойш багш нарт зориулсан 20 гаруй сургалтыг зохион байгуулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нар 100 хувь хамрагдсан.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулж буй сургалтууд, түүний үр дүнг үнэлсэн үнэлгээг хийж хэвшээгүй.
- Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаанд үндэслэн боловсруулах

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг стратеги төлөвлөлттэй уялдуулан, санхүүжилтийг нэмэгдүүлэх
- “Эдийн засаг” хөтөлбөрийн багш нарыг мэргэжлийн чиглэлээр нь гадаад, дотоодод богино хугацааны сургалтуудад хамрагдахад дэмжлэг үзүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа
- Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан
- Багш нарын нийтлүүлсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Багш нарын эрдэм шинжилгээний ажилд зарцуулсан төсөв, тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн багш нар олон улсын болон дотоодын санхүүжилттэй судалгааны 1 – 2 төсөлд жил бүр оролцож байна.
- Сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардал сүүлийн жилүүдэд өссөн дүнтэй.
- Сүүлийн 3 жилд тус тэнхимийн багш нар 11 өгүүлэл, 15 эрдэм шинжилгээний илтгэл, 7 гарын авлага, 3 зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна.
- Багш нарын бүтээлийг цахимжуулах ажлыг эхлүүлж, www.research.ubu.mn мэдээллийн системийг ашиглан, цахим санг үүсгэсэн байна.

Анхаарах асуудал:

- Олон улсын өндөр эрэмбийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл ховор байгааг анхаарах
- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эшлэгдсэн тооны судалгааг гаргах

Зөвлөмж:

- Олон улсын сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхэд нь багш нарт дэмжлэг үзүүлэх, судалгааны үр дүнг хөтөлбөрт болон хөтөлбөрийн сайжруулалтад хэрхэн ашиглаж байгааг тодорхойлох
- Багш нарын төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн үйл ажиллагаанд өгсөн хөндлөнгийн үнэлгээ
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл
- Багшийн хавтас

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийг аттестатчилах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон, сургалт заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, нийгмийн үйлчилгээ, гадаад хэл, сурган, сэтгэл судлал, мэргэжлийн чадвар гэсэн зургаан үзүүлэлтээр үнэлж байна. Багшийг аттестатчилах журам нь багшийг өсөж дэвжих нөхцөлийг бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийн оролцогч талын нэг болох оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг багш нэг бүрээр авч үр дүнг хэлэлцдэг.
- Багш нарын үнэлгээг өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний аргуудыг хослуулсан байдлаар ашигладаг.

Анхаарах асуудал:

- Багш нартай уулзсан уулзалтын үеэр сүүлийн 3 жилд цалин нэмээгүй, диплом удирдахад 0.2 кредит байгааг нэмэгдүүлэх зэрэг санал ирүүлж байсныг анхаарах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын журам
- Чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС нь Байгууллагын магадлан итгэмжлэлд 3 удаа орж магадлан итгэмжлэгдсэн. Сургуулийн хэмжээнд 15 хөтөлбөр нь “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл”-д орсон.

- ОУУБИС нь “Чанарын дотоод баталгаажуулалтын алба”-тай. Уг алба нь батлагдсан журмын хүрээнд Сургалтын албатай хамтран ажиллаж сургалтын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд хамтран ажилладаг.
- Хөтөлбөрийн дэд хороогоор оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, сургалтын технологи, хөтөлбөрийн үр дүнг хэлэлцэж чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг тасралтгүй хийдэг.
- Хөтөлбөрт оролцогчдын сэтгэл ханамжийн ханамжийн судалгааны үр дүнгээр, хамгийн доод нь үнэлгээ 2.8 байгаа нь сэтгэл ханамж харьцангуй өндөр байгааг илтгэнэ.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад, сүүлийн 2 жилд “Хичээлээс олж авсан онолын мэдлэг”, “Багшийн оюутнуудтай харилцах болон заах арга зүйн чадвар”, “Шалгалт, бие даалт, даалгаврыг цаг хугацаанд нь авч үнэлгээг тогтмол танилцуулдаг байдал” гэсэн үзүүлэлтэд өгсөн үнэлгээ буурсан байна. Хэдийгээр цар тахлын нөлөөгөөр хичээлийг 100 хувь цахимаар орсонтой холбоотой байж болох ч цаашид хийх ажлыг тодорхой төлөвлөх хэрэгтэй.

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайланг нэгтгэдэг байх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- “Эдийн засаг” мэргэжлээр төгсөгчдийн 92% нь ажлын байраар хангагддаг. Үүнээс 62 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна. Төгсөгчдийн 38% нь магистрын түвшний сургалтад, 7% нь докторын сургалтад суралцдаг.
- Нийт төсөгчдийн 17% нь төгсөөд шууд, 16% нь төгсөөд 3 сарын дотор ажилд орж байна. Төгссөнөөс хойш 4-7 сарын хугацаанд нийт төгсөгчдийн 42% нь ажилд ордог. Ажилд орох дундаж хугацаа 9 сар байна.
- Төгсөгчдийн ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлсийн судалгаагаар, төгсөгчдийн 49.55 хувь нь гадаад хэлний өндөр мэдлэгтэй тул ажилд орсон болох нь тогтоогдсон. Эндээс харахад, төгсөгчдийн гадаад хэлний ахисан түвшний мэдлэг нь давуу тал болж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн мөшгих судалгааны үр дүн, төгсөгчийн ажилд орох дундаж хугацаа зэрэг чухал үзүүлэлтүүдийг тайланд тусгаагүй байсан бөгөөд сургууль дээр ажиллах үеэр нотлох баримт, судалгааг үзэж байж тодруулсан тул цаашид Өөрийн үнэлгээний тайланд тусгах ёстой асуудлыг бүрэн тусгаж байх

Зөвлөмж:

- Төгсөгчдийн мөшгих судалгааг жил бүр шинэчилж байх

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа
- Төгсөгчдийн мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэхний хуулбарууд
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн үргэлжлүүлэн гадаадын их сургуульд магистрантурт суралцаж буй хувийн жин харьцангуй өндөр буюу ахисан түвшинд суралцагчдын 27.0 хувь нь гадаадын их сургуульд үргэлжлүүлэн суралцаж байна.
- БНСУ-ын их сургуулиудтай хос хөтөлбөр хэрэгжүүлж хөтөлбөрийг харилцан зөвшөөрдөг.
- Оюутан солилцооны хөтөлбөрийг БНСУ-ын сургуулиудтай амжилттай хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- “Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа”-ны үр дүнг тайланд тусгагдаагүй байсан тул цаашид Өөрийн үнэлгээний тайлан бичилтэд анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг олон улсын түвшинд, БНСУ-ын магадлан итгэмжлэлээр үнэлүүлэх боломжийг судлах

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

ОУУБИС-ын “Эдийн засаг” бакалаврын хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан			
2	Сургалтын үйл ажиллагаа	Бүрэн хангасан	2.1		<ul style="list-style-type: none"> • Сургалтын төлөвлөгөөнд тухайн мэргэжлээр суралцагчдын мэдлэг, ур чадварт хамааралгүй “Ерөнхий хими”, “Ерөнхий биологи” хичээлүүдийг сонголтоор оруулсан. • Мэргэжлийн хичээлүүдийн сонголт харьцангуй бага байна. • Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөр дэх зарим сэдвүүд давхардсан. • Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийгээгүй.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Бүрэн хангасан			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Бүрэн хангасан	4.3		<ul style="list-style-type: none"> • Ном сурах бичиг, багшийн хөгжил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах зардлын хувийн жин бага, сургуулийн стратеги төлөвлөгөөг санхүүжилттэй уялдуулаагүй. • Хөтөлбөрийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, элсэлтийн тодорхой бодлого гаргаагүй.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Бүрэн хангасан			
6	Багшийн үйл ажиллагаа	Бүрэн хангасан			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	Бүрэн хангасан			
ДҮГНЭЛТ		БҮРЭН ХАНГАСАН			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Оролцогч, сонирхогч талуудын эрэлт, хэрэгцээнд үндэслэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг бүрэн гүйцэд гаргах • БНСУ-ын их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж буй туршлага дээрээ тулгуурлан хөтөлбөрийн олон улсад болон БНСУ-д зөвшөөрөгдөх байдлыг баталгаажуулах боломжийг судлах • Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан ба сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцэж байгаа хэдий ч олон нийтэд түгээх мэдээллийн хэлбэр, сувгийг нэмэгдүүлэх • Төгсөгчийн загварыг нарийвчлан боловсруулж хэвлэгдсэн байгаа “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичигт оруулах • Төгсөгчдийн мэргэжлийн салбарт хөрвөх чадварыг судлахдаа гадаад, дотоодын ижил хөтөлбөрүүдээс туршлага судлах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Суралцагчийн сонгох хичээлийн тоог нэмэгдүүлэх, багшийг сонгох нөхцөлийг бүрдүүлэх • Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байгаа “Ерөнхий хими”, “Ерөнхий биологи” хичээлүүдийг хасаж тухайн хөтөлбөрөөр суралцагчдад мэргэжлийн чиглэлийн дагуу мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хичээлүүдийг оруулах • Мэргэжлийн хичээлүүдийн сонголтыг нэмэгдүүлэх • Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөр дэх сэдвийн давхардлыг арилгах • “Бизнесийн шинжилгээ” хичээлийг бакалаврын түвшинд судлуулах • Мэргэшүүлэх сонгон хичээлд мэргэжлийн чиглэлийн хичээлүүдийг нэмж оюутанд хичээл сонголтыг хийх боломжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, Зардал өгөөжийн шинжилгээ, Ногоон эдийн засаг, Нөөцийн эдийн засаг, Тоглоомын онол, Институцийн эдийн засаг, Нийгмийн эдийн засаг, Эрсдэлийн шинжилгээ гэх мэт. • Мэргэжлийн суурь болон Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах. Хичээлүүдийн стандарт хөтөлбөрүүдийг сайжруулахдаа Эдийн засгийн мэргэжлийн нэр хүнд бүхий сургуулиудаас мэргэшсэн багш нарын зөвлөгөөг авах • Сургалтын арга зүйг өөрчилж сайжруулснаар хүрсэн үр дүнг тодорхойлсон судалгааг хийх • Эдийн засгийн судалгаа, шинжилгээнд ашиглагддаг орчин үеийн Stata, R, Vensim, Smart PLS зэрэг программ хангамжуудын лицензийг худалдан авч сургалтдаа ашиглах • Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгааг нарийвчлан гүйцэтгэх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин,	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологийн хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, хүртээмжийг сайжруулах • Интернэтийн үйлчилгээний хурдыг сайжруулах, тасалдалгүй ажиллагааг хангах

технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Зайн сургалтыг явуулах боломжийг судлах • Олон улсын эрдэм шинжилгээний цахим сангуудыг нэмэгдүүлэх • Багш, судлаачдад зориулж гадаадын өндөр эрэмбийн сэтгүүлийг цахимаар унших эрхийг худалдан авах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн динамик шинжилгээг хийж хэвших, үр дүнг оролцогч талуудад эргэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх • Шинэчилсэн хөтөлбөрт ажил олгогчдоос санал авах, дүгнэлт гаргуулах, хэлэлцүүлэгт татан оролцуулах, судалгаа авах зэргээр тэдний хөтөлбөрийн сайжруулалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх • Мэргэжлийн холбоод, бизнесийн байгууллагуудтай судалгаа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах боломжит чиглэлүүдээ тодорхойлон, багш нарыг идэвхжүүлэх • Судалгааны санхүүжилттэй холбоотой гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах • Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайланг дэлгэрэнгүй байдлаар боловсруулах • Сургалтын төлбөрөөс гадна нэмэлт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах • Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургууль, тэнхимийн санхүүгийн бие даасан байдлыг бүрдүүлэх боломжийг судлах • Хөтөлбөрөөр суралцагчийн тоо харьцангуй цөөн тул хөтөлбөрийн онцлогийг сайтар таниулах, хөтөлбөрийн давуу талуудыг сурталчлах үе шаттай алхмуудыг тэнхимийн зүгээс санаачлан зохион байгуулах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Элсэгчдэд зориулсан мэдээллийн агуулгыг сайжруулах, элсэлтийн маркетингийн бодлогыг илүү тодорхой болгох, элсэгчдэд мэдээлэл түгээх сувгуудыг сайжруулах • Элсэгчдэд зориулсан мэргэжлийн чиглэл рүү хандсан арга хэмжээ зохион байгуулах • “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”, “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв”, “Хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх төв” зэрэг төвүүд, оюутны сурах таатай нөхцөлийг үлгэр жишээчээр бүрдүүлсэн байдлыг сурталчилгаанд ашиглах боломжтой. • “Эдийн засаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн зүгээс мэргэжлийн чиглэлээр явуулж буй дугуйлангийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөөтэй байх • Оюутны хөдөлмөр эрхлэх төв нь зөвхөн цагийн ажлаар бус, мэргэжлийн хэрэгцээнд тохирсон ажлыг байрыг санал болгоход анхаарах • Сургалтын төлбөр төлөх уян хатан гэрээг оюутанд санал болгох • Төгсөгчдийн товч анкетын загвар боловсруулж мэдээллийн санг бүрдүүлэх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хэдийгээр багшийн тоог нэмэгдүүлэх нь оюутны тоотой хамааралтай ч цаашид Эдийн засгийн мэргэжлийн хичээл заадаг багшийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлах

	<ul style="list-style-type: none"> • Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг стратеги төлөвлөлттэй уялдуулан, санхүүжилтийг нэмэгдүүлэх • “Эдийн засаг” хөтөлбөрийн багш нарыг мэргэжлийн чиглэлээр нь гадаад, дотоодод богино хугацааны сургалтуудад хамрагдахад дэмжлэг үзүүлэх • Олон улсын сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхэд нь багш нарт дэмжлэг үзүүлэх, судалгааны үр дүнг хөтөлбөрт болон хөтөлбөрийн сайжруулалтад хэрхэн ашиглаж байгааг тодорхойлох • Багш нарын төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайланг нэгтгэдэг байх • Төгсөгчдийн мөшгих судалгааг жил бүр шинэчилж байх • Хөтөлбөрийг олон улсын түвшинд, БНСУ-ын магадлан итгэмжлэлээр үнэлүүлэх боломжийг судлах
Шалгуур	Шаардлага
2.1	<ul style="list-style-type: none"> • Сургалтын төлөвлөгөөнд тухайн мэргэжлээр суралцагчдын мэдлэг, ур чадварт хамааралгүй “Ерөнхий хими”, “Ерөнхий биологи” хичээлүүдийг сонголтгоор оруулсан. • Мэргэжлийн хичээлүүдийн сонголт харьцангуй бага байна. • Мэргэжлийн хичээлүүдийн стандарт хөтөлбөр дэх зарим сэдвүүд давхардсан. • Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийгээгүй.
4.3	<ul style="list-style-type: none"> • Ном сурах бичиг, багшийн хөгжил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах зардлын хувийн жин бага, сургуулийн стратеги төлөвлөгөөг санхүүжилттэй уялдуулаагүй. • Хөтөлбөрийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, элсэлтийн тодорхой бодлого гаргаагүй.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн “Эдийн засаг” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Нийгмийн ухаан, сэтгүүл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:

Н.Нямаа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

С.Эрдэнэтуул

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

П.Эрдэнэбат

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Овог, нэр	Албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	С.Дэлгэрмаа	Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч ахлах багш Докторант	99255976	delgermaa.s@ulaanbaatar.edu.mn
2	Т.Булган	Эдийн засгийн тэнхимийн багш Ph.D, дэд профессор	99003047	bulgan.t@ulaanbaatar.edu.mn
3	Ц.Энхцэцэг	Эдийн засгийн тэнхимийн ахлах багш Ph.D	89006160	enkhtsetseg.ts@ulaanbaatar.edu.mn
4	В.Отгонжаргал	Эдийн засгийн тэнхимийн багш Ph.D, дэд профессор	88035419	otgonjargal.v@ulaanbaatar.edu.mn
5	Т. Ганхуяг	Эдийн засаг, бизнесийн сургуулийн захирал, бизнесийн тэнхимийн ахлах багш Ph.D	99152431	gankhuyag.t@ulaanbaatar.edu.mn
6	Л. Гүнжаргал	Бизнесийн тэнхимийн эрхлэгч ахлах багш Ph.D,	95956017	gunjargal.l@ulaanbaatar.edu.mn
7	Б.Бүжидмаа	Бизнесийн тэнхимийн ахлах багш	99076233	bujidmaa.b@ulaanbaatar.edu.mn
8	Ө.Энхтуяа гэрэл	Бизнесийн тэнхимийн ахлах багш	99173354	enkhtuyagerel.u@ulaanbaatar.edu.mn
9	Л. Ариунбат	Бизнесийн тэнхимийн багш.дэд профессор	99094205	ariunbat.l@ulaanbaatar.edu.mn

II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Овог, нэр	Хэддүгээр курс	Сонгосон байдал	Утас
1	Б.Ганди	4	УБ	80236789
2	Д.Ганбаяр	3	О.Н	89177582
3	Б.Лхам-Очир	3	УБ	88699623
4	Б.Янжинлхам	3	УБ	89909801
5	М.Нандинчимэг	3	УБ	99626596
6	Б.Мөнхбаяр	4	УБ	99047065
7	Л.Нандинцэцэг	4	О.Н (дотуур байр)	85858503
8	Э.Хишигдалай	4	О.Н	88560636
9	М.Солонго	4	О.Н (дотуур байр)	99532530
10	Б.Аюурзана	2	УБ	80030689
11	Б.Мөнхцацрал	2	УБ	80262434

12	Б.Булганхангай	2	УБ	99127403
13	Г.Энхтөгөлдөр	1	УБ	80327476
14	С.Бямбадорж	1	О.Н (дотуур байр)	86891108
15	Т.Түмэнбаяр	4	О.Н	96692418
16	О.Урангоо	1	О.Н	94128458
17	М.Адъяанацаг	4	О.Н	91334343
18	Д.Энхзул	1	УБ	85190222
19	О.Буманцэцэг	2	О.Н (дотуур байр)	80500274
20	Г.Түвшинжаргал	1	УБ	89112659

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог, нэр	Албан байгууллага	Албан тушаал	Утас
1	О.Чинзориг	“Капитал хаус	Захирал	99114777
2	С.Отгонсүрэн	“Глобал” их сургууль	Сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан захирал	99127256
3	Т.Эрдэнэчимэг	Говьсүмбэр аймгийн “Статистикийн газар	Дарга	99969633
4	Э.Бархасбадь	“Infinite Holding” ХХК	Захирал	88880007
5	Ц.Буяндэлгэр	“Wisteria” LLC	Ахлах менежер	94632888
6	Н.Гансүх	“Голомт” банк	Салбарын захирал	99026573
7	Б.Амарзаяа	Налайх дүүргийн тамгын газар	Албаны дарга	88058049
8	Я.Түмэнцэцэг	“Тесо” групп	Ахлах эдийн засаг	89984111
9	А.Алтангадас	“Улаанбаатар түл” ХХК	Төлөвлөлтийн албаны дарга	97111311
10	М.Мөнхбат	“ХААН” банк	Салбарын захирал	86567626
11	Г.Зулцэцэг	“Юни-газ” групп	Гадаад харилцааны албаны ахлах мэргэжилтэн	99441216
12	Б.Түвшинбаяр	“Сод Монгол” групп	Захирал	90999446
13	Ц.Ариунболд	“UP TECH” ХХК	Ерөнхий захирал	99870725
14	Б.Оюун-Эрдэнэ	“Монзун” констракшн	Ахлах менежер	99155379
15	Б.Баярсайхан	“Доктор авто сүлжээ”	Салбарын захирал	99094224

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог, нэр	Хэдэн оны төгсөгч	Албан тушаал	Утас
1	Х.Гэрлээ	2015	Монгол Сугалаа ХХК, Маркетингийн албаны дарга	91107757

2	Б.Оргилбат	2015	Капитрон банк, эдийн засагч, цахим карт мэргэжилтэн	80051589
3	Ж.Шижирням	2015	Төрийн банк, ахлах теллер	80079494
4	Э.Болормаа	2015	Голомт банк, зээлийн эдийн засагч	88787177
5	Г.Бат-Эрдэнэ	2015	Хаан банк, эдийн засагч	99553135
6	М.Батгүшиг	2016	Хаан банк, эдийн засагч	80058390
7	М.Баярманлай	2016	Бриж груп, Эври Дей, Импорт гадаад худалдааны хэлтэсийн дарга	88041609
8	М.Мөнхбаяр	2016	Хаан банк, зээлийн эдийн засагч	88352424
9	Б.Билэгсайхан	2016	Нет капитал ББСБ, эдийн засагч	94027471
10	Г.Намуу	2017	АНУ, Macquarie University, Олон улсын харилцааны магистрт сурч байна.	
11	Б.Алтанзаяа	2018	Голдан Финанс ББСБ, эдийн засагч	85522065
12	Э.Дэлгэрмаа	2018	Голомт банк, эдийн засагч	88071538
13	Ц.Буяндэлгэр	2018	Вистериа ХХК, захирал	94632888
14	Э.Батсүрэн	2018	Хаан банк, Харилцааны менежер	89898365
15	С.Даваадулам	2019	Maximus distribution, Brand specialist	88106358
16	Б.Цэцэгсайхан	2019	Mon application ББСБ, эдийн засагч	99971708
17	О.Энхманлай	2020	Нет капитал ББСБ, эдийн засагч	94025033
18	Б.Бат-Эрдэнэ	2020	Хөгжил Финанс ББСБ, зээлийн эдийн засагч	95484221

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
Намянжүгийн гудамж, Утас: 462046 Факс: 976-11-462040
E-mail: info@iuu.edu.mn, iuu.edu.mn

2022.04.29 № 2/168

танай _____-ны № _____-т

Шинжээчийн тайлантай танилцсан тухай

Тус сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн "Эдийн засаг" хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчийн багийн урьдчилсан тайлантай танилцлаа.

Цаашид бидний зүгээс шинжээчийн багийн өгсөн дүгнэлт, анхаарах зүйл, зөвлөмжийн дагуу өөрийн үнэлгээний тайлан, мэргэжлийн хөтөлбөрөө сайжруулж ажиллах болно.

ДЭД ЗАХИРАЛ *[Signature]* А.ХАНДМАА

